

Тус газар нь 6 удаагийн танхимын болон цахим сургалт зохион байгуулж харьяа байгууллагын 180 гаруй албан хаагчийг хамруулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч дээд шатны болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 21 удаагийн сургалтад давхардсан тоогоор 293 албан хаагчийг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүллээ. Аймгийн соёл урлагийн салбарт эхний хагас жилийн байдлаар ажиллаж буй нийт 163 ажилтнаас 62% буюу 101 нь мэргэжлийн ажилтан байна. Соёл урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр 5 оюутныг орон нутгийн бодлогоор дэмжин аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын төлбөрийн тэтгэлгээр суралцуулж байна. Соёлын байгууллагуудад ажиллаж буй мэргэжлийн бус 62 ажилтнаас 6 ажилтныг Соёл урлагийн их сургуульд эчнээгээр суралцуулан мэргэжил боловсролыг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна. Соёлын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, шинэ санал санаачилга хэлэлцэх, туршлага солилцох, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх, ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Хөгнийн хавар-2023” Соёлын салбарын ажилтан, албан хаагчдын нэгдсэн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж соёлын байгууллагын 150 гаруй албан хаагчид оролцлоо. Тус зөвлөгөөний хүрээнд Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалт, бүртгэн баримтжуулалтын арга туршлага, Соёл урлагийн үйлчилгээний арга туршлага, орлого төвлөрүүлэлт, Театрын менежмент, урын санг нэмэгдүүлэх, Бүх нийтийн соёлын боловсрол, Дугуйлан секцийг үр дүнтэй зохион байгуулах арга туршлага зэрэг сэдвээр илтгэл мэдээлэл хүргэж соёлын салбарын ажилтнуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Төрийн захиргааны дэс түшмэлийн гүйцэтгэх албан тушаал /Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Төсөв хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Хяналт шинжилгээ үнэлгээ статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ -4, Дэс түшмэлийн удирдах албан тушаал /Соёл урлагийн хэлтсийн дарга/-1, Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын-6 /Хөгжимт жүжгийн театрын дарга, Бүрэгхангай, Баяннуур, Тэшиг, Хялганат, Сайхан сумын Соёлын төвийн дарга/ нийт 11 сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсний дагуу Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх, шатлан дэвшүүлэх болзол журмын дагуу" сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж Тэшиг сумын Соёлын төвийн даргын албан тушаалд-2, Соёл урлагийн хэлтсийн даргын албан тушаалд-2, Бусад төрийн захиргааны гүйцэтгэх болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад тус бүр 1 иргэн оролцсон. Үүнээс тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн болон хамгийн өндөр оноо авсан-4 мэргэжилтэн, 1 хэлтсийн дарга, 1 соёлын төвийн даргыг журмын дагуу томилсон. Бүрэгхангай сумын Соёлын төвийн дарга, Хөгжимт жүжгийн театрын даргын сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 иргэний материал Авлигатай тэмцэх газарт хянагдаж байна.